



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/502

Булган сум

┌ Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын
сургуульд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг зөөлөн эдлэлээр хангахад 15,000,000 (арван таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ТҮРЭВ-ОЧИР

